

**ЗУРАГТ БОЛОН БУСАД ЦАХИЛГААН БАРАА НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Зурагт болон бусад цахилгаан бараа нийлүүлэх

**Харьцуулалт/
гэрээний дугаар:** ТБ/201901116

Батлагдсан төсөв: 49,320,000

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Төрийн банк нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Зурагт болон бусад цахилгаан бараа нийлүүлэх** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө **ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ**-ээр (www.tender.gov.mn) ирүүлнэ үү.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн өдрийн 10 цаг 10 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дээрх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр,
2-р давхар, 202 тоот өрөө,

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
<p>ТӨӨЗ 1.1</p>	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал /Үнийн саналын маягтын дагуу ирүүлэх/ 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Байгууллагын тухай танилцуулга 4. Татварын цахим тайлангийн систем (www.e-tax.mta.mn)-ээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна /Тодорхойлолтын доод хэсэгт байрлах баркод болон тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаар гаргацтай байх шаардлагатай/. 5. Барааны талаар дэлгэрэнгүй танилцуулга /Техник үзүүлэлт/ 6. Бараа нийлүүлэх хуваарь 7. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ 8. Харилцагч банкны тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ /Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлолт авна/. 9. 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ. /Сангийн яамны И-баланс цахим системд шивэгдэж баталгаажсан тайлан байх/ 10. 2017, 2018 оны аль нэг жилд ижил төстэй бүтээгдэхүүн нийлүүлсэн гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. Туршлагын мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлнэ. Гэрээ, актыг заавал хавсаргаж ирүүлнэ /Зарлагын баримтыг акт гэж тооцохгүй/. 11. Баталгаат хугацаа техникийн тодорхойлолтонд заагдсаны дагуу байх. /нотолсон албан тоот ирүүлэх/ 12. Баталгаат хугацаанд нийлүүлсэн бараанд гарсан үйлдвэрлэгч талын аливаа асуудал, гэмтэл, доголдлыг үнэ төлбөргүй сольж өгөх замаар бүрэн шийдвэрлэнэ. /Баталсан албан бичиг ирүүлнэ/ 13. Нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээг шуурхай хийх үйлдвэрлэгчийн сертификат эсвэл түүнтэй дүйцэхүйц мэргэшсэн сертификаттай мэргэжлийн боловсон хүчинтэй болохыг баталсан албан бичиг ирүүлнэ. /сертификатын хуулбар хавсаргах/ 14. Санал болгож буй барааг санал болгосон үнэдээ багтаан хугацаандаа нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. 15. Төрийн банкны зүгээс тухайн тендерт оролцогчийн харилцагч банк, харьяа татвар, шүүх болон бусад байгууллагад хандаж, түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг 16. Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй. 17. Гадаад хэл дээрх бүх материалыг Монгол хэл рүү орчуулан ирүүлнэ.
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ (www.tender.gov.mn) д аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, Ерөнхий үйлчилгээний хэлтэс, 2-р давхар, 202 тоот өрөө</p> <p>Огноо: 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 10 минут</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Хөрөнгийн нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт	тоо	Нийлүүлэгч
1	Зурагт LED дэлгэц 43"	<p>Шинэ Sony түүнтэй дүйцэхүйц</p> <ul style="list-style-type: none"> • 43" –с дээш LED Smart TV • ТВ opera browser-той • Full HD, 1920 x 1080 түүнээс дээш • HDMI x 2 <, Composite AV, USB, LAN, • Multimedia file play /photo, video/ from external USB storage • power: 100-250V AC 50/60Hz • • Баталгаат хугацаа 1,5 жил 	1	Олон улсын стандартын шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүн нийлүүлдэг байх.
2	Дэлгэц 44"	<p>Шинэ</p> <ul style="list-style-type: none"> • 40-44" LED TV • Full HD, 1920 x 1080 • HDMI x 2<, Composite AV, S-Video, USB, VGA+audio in, • Multimedia file play /photo, video/ from external USB storage • power: 100-250V AC 50/60Hz • Баталгаат хугацаа 1,5 жил 	1	
3	Ханшийн зурагт	<p>Шинэ</p> <ul style="list-style-type: none"> • 42" LED Smart TV • ТВ opera browser-той • Full HD, 1920 x 1080 • HDMI x 2<, Composite AV, S-Video, USB, VGA+audio in, • Multimedia file play /photo, video/ from external USB storage • power: 100-250V AC 50/60Hz • Баталгаат хугацаа 1,5 жил 	9	
4	42 инч TV	<p>Шинэ</p> <ul style="list-style-type: none"> • 40-44" LED TV • Full HD, 1920 x 1080 • HDMI x 2<, Composite AV, S-Video, USB, VGA+audio in, • Multimedia file play /photo, video/ from external USB storage • power: 100-250V AC 50/60Hz • Баталгаат хугацаа 1,5 жил 	1	
5	Ханшийн зурагт тодотгол 2018	<p>Шинэ</p> <ul style="list-style-type: none"> • 42" LED Smart TV • ТВ opera browser-той • Full HD, 1920 x 1080 • HDMI x 2<, Composite AV, S-Video, USB, VGA+audio in, • Multimedia file play /photo, video/ from external USB storage • power: 100-250V AC 50/60Hz • Баталгаат хугацаа 1,5 жил 	28	
6	Тоос сорогч /энгийн/	<p>Samsung эсхүл түүнтэй дүйцэхүйц</p> <ul style="list-style-type: none"> • Оролтын хүчдэл 230V • Оролтын давтамж 50/60 Hz • Дуу чимээ 63dB • Хүчин чадал 1600-2000Вт • Соролтын хүч 3000 Ватт • Шүүх систем Anti • Уутгүй байх • Хог хуримтлуулах багтаамж 2.5 литр • Цахилгаан утасны урт 5м • Чирэхэд зориулсан дугуйтай байх • Баталгаат хугацаа 1 жил 	5	
7	Угаалгын машин /хагас автомат/	<ul style="list-style-type: none"> • Төрөл – Хагас автомат • Оролтын хүчдэл 230V • Дуу чимээ 63dB • Угаах багтаамж 14 кг • Сэгсрэх багтаамж 7.5кг • Бохироо гадагш шахдаг байх • Баталгаат хугацаа 1 жил 	1	

8	Утасны аппарат	ETHERNET Phone эсхүл түүнтэй дүйцэхүйц <ul style="list-style-type: none"> • Tone /DTMF/, pulse • Ringer volume level 3 /low, medium, high/ • Power telephone line 12V, 45mA 	4	
9	Ууран индүү	Philips эсхүл түүнтэй дүйцэхүйц <ul style="list-style-type: none"> • Оролтын хүчдэл 230V • Оролтын давтамж 50/60 Hz • Хүчин чадал 2400Вт • Уур гаралт 45 г/мин • Усны савны багтаамж 320 мл • Жин 1.25 кг • Баталгаат хугацаа 1 жил 	1	
10	Диктафон /8GB/	<ul style="list-style-type: none"> • Шинэ байх • Built in stereo mic-тэй байх • Built in LCD display-тэй байх • Esase/Protect функцтэй байх • 3,5 earphone/mic standart jack-тай байх • Audio standart: MP3, 8-192kbps болон дээш WMA, CM(wav), AAC байх • PC connect: high speed USB байх • Дотоод санах ой 4GB болон түүнээс дээш, нэмэлт санах ойн (32GB хүртэл) оролттой байх • Нэмэлт 4GB багтаамжтай мемори карттай байх • MAC OSK, Window 7 болон үүнээс үйлдлийн системд нийцэж ажилладаг програмтай байх • Дахин цэнэглэдэг эсвэл AAA хэмжээтэй батерейтэй байх • Функцууд: Low-cut filter, Digital Pitch Control, Safety lock8 Voice operated recording, Intellgent Noise Cut8 USB direct input, Voice E-mail Function, Calendar8 Microphone sensitivity selection, USB bus-powered 	3	

1. **Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
2. **Баглаа, боодол:** Бараа нь баглаа боодолтой, шинэ байна. Баглаа боодол бүрийн гадна талд бүтээгдэхүүний нэр, тоо ширхэгийг тэмдэглэсэн товъёог наасан байна
3. **Бараа хүргэх, тогтоон байршуулах газар:**

Барааг захиалагчийн товлосон газар хүргэж төрийн банкны бараа, ажил үйлчилгээ хүлээлцэх актаар хүлээлгэн өгч гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулна.

4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	Зурагт LED дэлгэц 43"	1	ширхэг	Техникийн тодорхойлолт 3-т заасан	Гэрээнд заасан хугацаагаар		
2	Дэлгэц /44"/	1	ширхэг				
3	Ханшийн зурагт	9	ширхэг				
4	42 инч LCD TV	1	ширхэг				
5	Ханшийн зурагт нийлүүлэх тодотгол - 2018	28	ширхэг				
6	Тоос сорогч /энгийн/	5	ширхэг				
7	Угаалгын машин /Хагас автомат/	1	ширхэг				
8	Утасны аппарат	4	ширхэг				
9	Ууран индүү	1	ширхэг				
10	Диктафон /4GB/	3	ширхэг				

Жич: Тээвэрлэх, хүргэх, суурилуулж, ажиллагаанд бүрэн оруулах ажлыг нийлүүлэгч тал хариуцна.

1. Хүргэлт болон бусад шаардагдах материал, зардлыг Нийлүүлэгч тал хариуцна.
2. Бүтээгдэхүүний ашиглалтын зааварчилгаа бүхий мэдээлэлтэй байх.

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Төрийн банкны гүйцэтгэх захирал Г.Дөлгөөн танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Зурагт LED дэлгэц 43"							
Дэлгэц /44"/							
Ханшийн зурагт							
42 инч LCD TV							
Ханшийн зурагт нийлүүлэх тодотгол - 2018							
Тоос сорогч /энгийн/							
Угаалгын машин /Хагас автомат/							
Утасны аппарат							
Ууран индүү							
Диктафон /4GB/							
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<p>1. Шалгах болон турших</p>	<p>1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана</p>
<p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</p>	<p>2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ</p>
<p>3. Оюуны өмчийн эрх</p>	<p>3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна</p>
<p>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</p>	<p>4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно</p>
<p>5. Баталгаат засварын хугацаа</p>	<p>5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 12 сараас доошгүй байна</p>
<p>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</p>	<p>6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй</p>
<p>7. Төлбөр</p>	<p>7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш хоногийн дотор шуурхай хийнэ</p>
<p>8. Бараа нийлүүлэх хуваарь</p>	<p>8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө</p>
<p>9. Алданги оногдуулах</p>	<p>9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй</p>
<p>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг</p>	<p>10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна</p>

цуцлах	
11.Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Зурагт болон бусад цахилгаан бараа нийлүүлэх ТБ/201901116
ГЕН 3.1	Төслийн менежер нь: Төрийн банк, Төв байр-2, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр нь: Гэрээнд заасан хугацаагаар Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээнд заасан хугацаагаар
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 1-1,5 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна.
ГЕН 13.1	Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;

¹ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]